



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/52

Бор-Өндөр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20 дахь хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр Тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.4, 2.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИАРМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын “Хүүхдийн зөвлөл”-өөс гаргасан санал буюу “Бор-Өндөр цогцолбор сургуулийн Дотуур байрны ариун цэврийн өрөөнд нэмэлт засвар хийх” ажлын хүрээнд зарцуулагдах 3 460 000 (гурван сая дөрвөн зуун жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсугай.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулах 3 460 000 (гурван сая дөрвөн зуун жаран мянга) төгрөгийг холбогдох хууль, журмын дагуу зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ